<table>
<tr><th colspan="3">"Төрийн банк" ХК-ийн хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/</th></tr>
<tr><td colspan="3">Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</td></tr>
<tr><td colspan="2">Тайлагнах хугацаа</td><td>2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр</td></tr>
<tr><td colspan="2" rowspan="4">Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</td><td>Компанийн нэр: "Төрийн банк" ХК</td></tr>
<tr><td>УБД: 9016001018</td></tr>
<tr><td>Үнэт цаасны код: MN00SBM05643</td></tr>
<tr><td>Утасны дугаар: 976-11-310103</td></tr>
<tr><td colspan="2">Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</td><td>"Монголын хөрөнгийн бирж" ХК</td></tr>
<tr><td colspan="2">Бизнесийн үйл ажиллагааны салбар</td><td>Банк, санхүү</td></tr>
<tr><td colspan="2">Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</td><td>755,096,250</td></tr>
<tr><td colspan="2">Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</td><td>Тайланг бэлтгэсэн : О.Нандинжаргал /Хөрөнгө зохицуулалтын газрын үнэт цаасны зах зээлийн шинжээч/
Хянасан: С.Болор-Эрдэнэ /Тогтвортой хөгжил хариуцсан дэд захирал/</td></tr>
<tr><td>1</td><td colspan="2">Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</td></tr>
<tr><td></td><td>Санхүүгийн байдлын үзүүлэлт
Орлогын тайлан
Өмчийн өөрчлөлтийн тайлан
Мөнгөн гүйлгээний тайлан</td><td>Хагас жилийн санхүүгийн тайланг хавсаргав.
Хавсралт №1</td></tr>
<tr><td>2</td><td colspan="2">Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</td></tr>
<tr><td></td><td colspan="2">Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо нь Банкны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг улирал тутам хэлэлцэн хянан үзэж, холбогдох санал, дүгнэлтийг гарган ажилладаг. Тайлант хугацааны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг 2026 оны 7 дугаар сарын 25-ны дотор Аудитын хороогоор хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.</td></tr>
<tr><td>3</td><td colspan="2">Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</td></tr>
<tr><td>3.1</td><td>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</td><td>Санхүүгийн тайлангаар балансын гол үзүүлэлтүүд болох нийт активын хэмжээ 2026 оны эхний хагас жилийн байдлаар 2025 оны эцэстэй харьцуулахад 15.8 хувиар өсч 7,783.8 тэрбум төгрөгт, үүнээс голлох орлого олдог активууд болох нийт зээл, үнэт цаасны үлдэгдэл 17.5 хувиар өсч 6,645.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.
Нийт пассивын хэмжээ өмнөх оны эцэстэй харьцуулахад 17.0 хувиар өсч 7,066.1 тэрбум төгрөгт, өөрийн хөрөнгийн хэмжээ 5.2 хувиар өсч 717.8 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна.
Орлогын тайлангийн гол үзүүлэлтүүд болох хүүгийн орлого 2026 оны эхний хагас жилийн байдлаар 493.7 тэрбум төгрөг, хүүгийн зардал 321.0 тэрбум төгрөг байна. Банк 2026 оны эхний хагас жилийн байдлаар 64.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 105.3 хувиар өссөн байна.
Банкны өөрийн хөрөнгийн өгөөж 2026 оны эхний хагас жилийн байдлаар 19.5 хувь, активын өгөөж 1.9 хувь байна.</td></tr>
<tr><td>3.2</td><td>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжит үзүүлэлт</td><td>Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа үзүүлэлт /LIQ/ 2026 оны эхний хагас жилийн байдлаар 38.96 хувийн /зохистой харьцаа >25%/ гүйцэтгэлтэй гарсан ба 2025 оны жилийн эцэстэй харьцуулахад 6.43 нэгж хувиар өссөнд олон улсын зах зээлд нэмэлтээр 100.0 сая ам.долларын бондыг гаргасан нь зэрэгээр нөлөөлсөн.
Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт:
<table>
<tr><th>Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт</th><th>Байвал зохих</th><th>Биелэлт 2026.06.30</th></tr>
<tr><td>Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа</td><td>>9%</td><td>15.76%</td></tr>
<tr><td>Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа</td><td>>12%</td><td>15.76%</td></tr>
<tr><td>Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт</td><td>>25%</td><td>38.96%</td></tr>
<tr><td>Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)</td><td><(+-15%)</td><td>-1.30%</td></tr>
<tr><td>Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)</td><td><(+-30%)</td><td>-2.45%</td></tr>
</table></td></tr>
</table>

3.3	*Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл*	Монгол Улсын төсвийн зарлага өмнөх оны мөн үеэс 18.7 хувиар өсөж, зарим төрлийн татварын орлого буурсны нөлөөгөөр улсын төсөв 1.4 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан нь инфляц болон бодлогын хүү өсөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Харин уул уурхайн экспортын өсөлтийн үр дүнд худалдааны тэнцлийн ашиг нэмэгдэж, гадаад валютын албан нөөц 7.6 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд мөнгөний нийлүүлэлт жилийн дүнгээр 26.8 хувиар өсөхөд дэмжлэг үзүүлэв. Монголбанк бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалсан бөгөөд инфляцын эрсдэл үргэлжилсэн тохиолдолд мөнгөний хатуу бодлого цаашид ч өндөр түвшинд хадгалагдах төлөвтэй байна. Төрийн банк тайлант хугацаанд 2.3 сая харилцагчид 150 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэн ажиллаж, харилцагчдын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг өргөжүүлж, дижитал үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр шинэчлэлүүдийг хэрэгжүүллээ. Энэ хүрээнд “Бизнес эрхлэгч ахмадыг дэмжих зээл”, “Алт олборлолтын зээл”, “Хязгаарлагдмал зориулалтын данс”, “Ногоон хадгаламжийн сертификат”, “Youth” виртуал карт, SplendorPlus карт, мөн SoftPOS үйлчилгээг шинээр зах зээлд нэвтрүүлэв. Үүний зэрэгцээ дижитал банкны үйлчилгээний хүртээмж, хэрэглэгчийн туршлагыг сайжруулах зорилгоор Төрийн банкны харилцагчид ДАН системийн тоон гарын үсгийг ашиглан Гялсбанк үйлчилгээнд онлайнаар бүртгүүлэх боломжийг бүрдүүлж, Гялсбанканд банк хооронд нэхэмжлэл илгээх, хүлээн авах үйлчилгээг нэвтрүүллээ. Мөн цахим төлбөрийн баримтын системийг шинэчилж POSAPI 3.0 платформд амжилттай шилжүүлэн, Төрийн сантай хамтран төрийн үйлчилгээний төлбөр, торгууль, татвар, гаалийн төлбөрийг нэг цэсээр төлөх боломжийг бий болгосон нь цахим үйлчилгээний хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэв.
3.4	*Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/*	Тайланг хавсаргав. Хавсралт №2
4	*Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/*	Холбогдох мэдээллийг хавсаргав. Хавсралт №3
5	*Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл*	
	Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд хувьцаа санал болгон хөрөнгө татан төвлөрүүлээгүй.	
6	*Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл*	Холбогдох мэдээллийг хавсаргав. Хавсралт №4
7	*Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл*	
	“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/, Гүйцэтгэх удирдлага гэсэн удирдлагын дараалсан бүтэцтэй, компанийн сайн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа хэвшил болгон хэрэгжүүлэн банкны засаглалыг сайжруулан ажиллаж байна. ТУЗ нь 2026 оны эхний хагас жилд нийт 15 удаа, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурал нийт 21 удаа тус тус хуралдаж, цаг үеийн холбогдох асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж, үүрэг даалгавар тухай бүр өгч ажилласан.	
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо: 2026 оны 07 дугаар сарын 07-ны өдөр		
Овог, нэр: Д.Сугар Албан тушаал: Бизнес хариуцсан Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч Гарын үсэг: *(Тамга/тэмдэг)*		
Овог, нэр: Х.Лхагвасүрэн Албан тушаал: Эрсдэл, санхүү хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч Гарын үсэг:		
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2026 оны 07 дугаар сарын 07-ны өдөр		
Овог, нэр: С.Болор-Эрдэнэ Албан тушаал: Тогтвортой хөгжил хариуцсан дэд захирал Гарын үсэг:		

ТӨРИЙН БАНКНЫ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/		2025.12.31	2026.06.30
	Балансын зүйл	**Эхний үлдэгдэл**	**Эцсийн үлдэгдэл**
1	**ХӨРӨНГӨ**		
1.1	**Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**	**1,352,544,305,685**	**1,760,397,814,146**
1.1.1	Бэлэн мөнгө	41,951,152,799	71,642,122,450
1.1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	365,397,745,224	258,167,245,387
1.1.3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	945,052,365,600	1,430,502,894,200
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	143,042,063	85,552,109
1.2	**Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө**	**508,255,003,768**	**643,309,188,492**
1.2.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгө	506,454,541,119	641,590,255,948
1.2.2	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	1,836,706,634	1,859,695,720
1.2.3	Бусад хөрөнгө	0	0
1.2.4	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	0	0
1.2.5	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан	-36,243,985	-140,763,177
1.3	**Хөрөнгө оруулалт**	**542,717,145,079**	**764,415,209,772**
1.3.1	Арилжааны үнэт цаас	12,543,761	10,230,180
1.3.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	218,752,179,435	410,031,631,154
1.3.3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	0	0
1.3.4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас	120,711,220,482	149,889,556,267
1.3.5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	0	0
1.3.6	Барьцаанд байгаа үнэт цаас	191,699,094,262	192,732,467,946
1.3.7	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	11,637,860,824	13,386,745,161
1.3.8	Үнэт цаасны эрсдэлийн сан	-95,753,684	-1,635,420,936
1.4	**Зээл (цэвэр дүнгээр)**	**4,050,350,416,086**	**4,322,392,643,794**
1.4.1	Хэвийн зээл	3,924,022,617,962	4,193,654,386,316
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	61,576,483,008	68,940,022,350
1.4.3	Хэвийн бус зээл	21,720,978,116	22,516,781,279
1.4.4	Эргэлзээтэй зээл	15,091,526,301	21,078,962,702
1.4.5	Муу зээл	154,627,052,813	155,741,630,372
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	-56,832,184,937	-57,460,913,773
1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	96,376,988,779	90,658,131,472
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	-166,233,045,958	-172,736,356,925
1.5	**Дериватив санхүүгийн хөрөнгө**	**22,868,202,028**	**35,621,569,645**
1.6	**Бусад санхүүгийн хөрөнгө**	**1,920,612,354**	**813,480,287**
1.6.1	Бусдаас авах авлага (цэвэр дүнгээр)	1,920,612,354	813,480,287
1.6.2	Банк, салбар хоорондын тооцоо	0	0
1.6.3	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	0	0
1.6.4	Бусад	0	0
1.7	**Бусад санхүүгийн бус хөрөнгө**	**48,397,527,961**	**46,710,590,603**
1.7.1	Бусад тооцоо	38,016,442,808	37,832,066,391
1.7.2	Бараа материал, үнэ бүхий зүйл	7,228,668,315	5,779,027,039
1.7.3	Үнэт металл (цэвэр дүнгээр)	0	0
1.7.4	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	3,060,479,188	2,901,929,656
1.7.5	Татварын авлага	91,300,650	193,436,236
1.7.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0	0
1.7.7	Бусад	637,000	4,131,281
1.8	**Үндсэн хөрөнгө**	**184,027,217,216**	**199,556,124,218**
1.9	**Хөрөнгө оруулалтын зорилалттай үл хөдлөх хөрөнгө**	**2,189,557,450**	**2,189,557,450**
1.10	**Борлуулах зорилалттай хөрөнгө**	**3,060,120,963**	**2,975,476,999**
1.11	**Бият бус хөрөнгө**	**5,484,016,545**	**5,466,276,170**
1.12	**Нийт хөрөнгийн дүн**	**6,721,814,125,136**	**7,783,847,931,576**
2	**ӨР ТӨЛБӨР**		
2.1	**Харилцах**	**1,123,561,512,939**	**1,925,975,930,146**
2.1.1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	1,123,561,512,939	1,925,739,264,522
2.1.2	Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	0	236,665,624
2.2	**Хадгаламж**	**3,018,277,687,104**	**3,003,496,585,811**
2.2.1	Хугацаагүй хадгаламж	367,620,604,866	415,556,735,173
2.2.2	Хугацаатай хадгаламж	2,549,233,889,786	2,477,817,203,722
2.2.3	Бусад төрлийн хадгаламж	2,000,000	6,300,000

2.2.4	Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	101,421,192,452	110,116,346,916
2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	**782,717,996,346**	**642,635,420,711**
2.3.1	Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж	314,631,540,338	260,479,233,401
2.3.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хугацаа хэтэрсэн зээлийн дүнг оруулсан)	455,420,747,185	369,023,514,638
2.3.3	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	0	0
2.3.4	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	12,665,708,823	13,132,672,672
2.4	Бусад эх үүсвэр	**1,042,819,650,410**	**1,427,004,052,215**
2.4.1	Банкнаас гаргасан өрийн бичиг	0	0
2.4.2	Банкнаас гаргасан үнэт цаас	711,332,000,000	1,076,432,854,865
2.4.3	Төслийн зээлийн санхүүжилт	182,652,460,265	202,638,803,027
2.4.4	Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (репо)	105,954,280,000	105,954,280,000
2.4.5	Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	0	0
2.4.6	Бусад	28,607,911,037	24,006,292,606
2.4.7	Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	-5,200,382,435	-9,507,702,979
2.4.8	Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	19,473,381,542	27,479,524,696
2.5	Дериватив санхүүгийн өр төлбөр	**24,403,010,349**	**21,506,699,354**
2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	**33,676,000,733**	**25,467,701,677**
2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	**14,030,706,830**	**19,975,922,605**
2.8	Хоёрдогч өглөг	**0**	**0**
2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	**0**	**0**
	Нийт өр төлбөрийн дүн	**6,039,486,564,710**	**7,066,062,312,519**
3	**ӨӨРИЙН ХӨРӨНГӨ**		
3.1	**Хувь нийлүүлсэн хөрөнгө**	**188,774,062,500**	**188,774,062,500**
3.1.1	Давуу эрхийн хувьцаа	0	0
3.1.2	Энгийн хувьцаа	188,774,062,500	188,774,062,500
3.2	**Нэмж төлөгдсөн капитал**	**14,652,725,000**	**14,652,725,000**
3.3	**Халаасны хувьцаа**	**0**	**0**
3.4	**Дахин үнэлгээний нэмэгдэл**	**42,310,184,890**	**52,834,118,846**
3.5	**Хуримтлагдсан ашиг, алдагдал**	**408,330,863,087**	**433,395,979,226**
3.6	**Бусад өөрийн хөрөнгө**	**28,259,724,949**	**28,128,733,485**
3.6.1	Хувьцааны опцион	0	0
3.6.2	Нөөцийн сан	693,668,759	693,668,759
3.6.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сан	0	0
3.6.4	Эрсдэлийн сангийн нөөц	23,212,717,007	23,212,717,007
3.6.5	Нийгмийн хөгжлийн сан	628,478,265	628,478,265
3.6.6	Хөрвөх өр төлбөр	0	0
3.6.7	Хувьцааны баталгаа бүхий зээл	0	0
3.6.8	Бусад	3,724,860,918	3,593,869,455
3.7	**Өөрийн хөрөнгийн дүн**	**682,327,560,426**	**717,785,619,057**
4	**Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн**	**6,721,814,125,136**	**7,783,847,931,576**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ӨЛЗАНТӨР

БИЗНЕС ХАРИУЦСАН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТЭРГҮҮН ОРЛОГЧ Д.СУГАР

САНХҮҮГИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ Д.ЖАДАМБАА

ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.БУЯНТОГТОХ

ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХЭЛТСИЙН ХЯНАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН Д.НАРАНЦАЦРАЛ

ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХЭЛТСИЙН ТАЙЛАНГИЙН МЭРГЭЖИЛТЭН Д.ЖАРГАЛМАА

ТӨРИЙН БАНКНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/		2025.12.31	2026.06.30
	Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:**	***	***
1.1	**Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)**	**123,945,913,657**	**83,803,967,899**
1.2	**Орлого, зардлын тохируулга:**	**-262,993,313,084**	**-149,185,761,895**
1.2.1	Эрсдэлийн сангийн зардал (+)	457,697,182	8,383,655,363
1.2.2	Элэгдэл, хорогдлын зардал (+)	24,341,292,120	14,546,380,367
1.2.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)	0	0
1.2.4	Хуримтлуулсан хүүгийн орлого (-)	-825,788,666,011	-493,652,888,227
1.2.5	Хуримтлуулсан хүүгийн зардал (+)	537,999,572,371	320,994,084,412
1.2.6	Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)	15,872,704	543,006,190
1.2.7	Бусад олз (-), гарз (+)	-19,081,450	0
1.3	**Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга:**	**-971,120,464,975**	**184,633,024,321**
1.3.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	-101,004,402,740	-135,054,184,724
1.3.2	Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)	-11,031,125,716	-125,645,600,760
1.3.3	Зээлийн өсөлт (-), бууралт (+)	-672,615,750,437	-286,142,477,694
1.3.4	Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	-18,626,685,648	-11,646,235,550
1.3.5	Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	-14,983,355,042	-31,147,074,680
1.3.6	Харилцах, хадгаламжийн өсөлт (+), бууралт (-)	-119,535,670,244	796,565,136,002
1.3.7	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)	-218,880,334,909	-139,615,611,786
1.3.8	Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	195,073,320,836	106,332,999,697
1.3.9	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	-9,516,461,076	10,986,073,816
1.4	**Бусад тохируулга:**	**245,586,685,864**	**139,583,196,000**
1.4.1	Авсан хүү (+)	845,029,115,367	497,622,861,196
1.4.2	Төлсөн хүү (-)	-571,333,335,735	-338,399,011,502
1.4.3	Орлогын татварын төлөлт (-)	-27,536,094,424	-19,638,391,010
1.4.4	Эрсдэлийн сангаас хаасан зээл, авлага (-)	-572,999,344	-2,262,684
1.4.5		0	
1.5	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**-864,581,178,538**	**258,834,426,324**
2	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:**	***	***
2.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**20,198,459,675,688**	**134,221,132,045**
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0	0
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0	0
2.1.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны орлого	0	0
2.1.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0	0
2.1.5	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	20,197,995,353,336	0
2.1.6	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0	10,038,948,443
2.1.7	Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого	0	124,181,601,979
2.1.8	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас борлуулсны орлого	0	0
2.1.9	Хүлээн авсан ногдол ашиг	0	581,623
2.1.10	Бусад мөнгөн орлого	464,322,352	0
2.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**-20,328,448,417,550**	**-215,800,141,329**
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	28,427,667,602	5,856,453,133
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,432,703,837	1,174,689,003
2.2.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0	0
2.2.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0	0
2.2.5	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0	43,847,711,000
2.2.6	Борлуулахад бэлэн үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	0	164,921,288,194
2.2.7	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	0	0
2.2.8	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	20,298,588,046,112	
2.2.9	Бусад мөнгөн зарлага	0	
2.3	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**-129,988,741,863**	**-81,579,009,284**
3	**Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:**	***	***
3.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**1,995,874,777,655**	**1,130,165,304,255**
3.1.1	Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан	1,300,191,311,320	775,146,321,064
3.1.2	Хөөрдөгч өглөгөөс хүлээн авсан	0	0
3.1.3	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	695,683,466,335	355,018,983,192
3.1.4	Төрөл бүрийн хандив	0	0
3.1.5	Бусад	0	0
3.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**-1,408,045,081,686**	**-899,567,212,835**
3.2.1	Бусад эх үүсвэрт төлсөн	1,353,215,142,617	844,307,758,993
3.2.2	Хөөрдөгч өглөгт төлсөн	0	0
3.2.3	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	6,730,307,944	16,145,468,092
3.2.4	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	0	0
3.2.5	Төлсөн ногдол ашиг	48,099,631,125	39,113,985,750
3.2.6	Бусад	0	0
3.3	**Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**587,829,695,970**	**230,598,091,421**
4	Валютын ханшийн зөрүү	0	0
5	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**-406,740,224,430**	**407,853,508,461**
6	**Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**1,759,284,530,115**	**1,352,544,305,685**
7	**Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**1,352,544,305,685**	**1,760,397,814,146**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ө.ГАНТӨР

БИЗНЕС ХАРИУЦСАН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТЭРГҮҮН ОРЛОГЧ Д.СУГАР

САНХҮҮГИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ Д.ЖАДАМБАА

ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.БУЯНТОГТОХ

ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХЭЛТСИЙН ХЯНАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН Д.НАРАНЦАЦРАЛ

ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХЭЛТСИЙН ТАЙЛАНГИЙН МЭРГЭЖИЛТЭН Д.ЖАРГАЛМАА

ТӨРИЙН БАНКНЫ ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/		2025.12.31	2026.06.30
	Орлого, зардлын зүйл	**Өмнөх үеийн дүн**	**Тайлант үеийн дүн**
1	**Хүүгийн орлого**	**825,788,666,011**	**493,652,888,227**
1.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгийн	3,853,596,361	2,223,658,949
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	7,788,741,993	743,395,293
1.3	Үнэт цаасны	141,118,247,742	83,201,772,049
1.4	Зээлийн	645,479,251,258	388,063,478,815
1.5	Бусад хүүгийн орлого	27,548,828,657	19,420,583,122
2	**Хүүгийн зардал**	**537,999,572,371**	**320,994,084,412**
2.1	Харилцахад төлсөн хүү	15,806,541,323	8,351,074,407
2.2	Хадгаламжинд төлсөн хүү	362,359,700,601	181,710,778,074
2.3	Зээлийн хүүгийн зардал	54,481,058,570	22,089,177,510
2.4	Үнэт цаасны хүүгийн зардал	35,227,533,392	47,291,985,062
2.5	Бусад хүүгийн зардал	70,124,738,486	61,551,069,359
3	**Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]**	**287,789,093,639**	**172,658,803,815**
4	**Эрсдэлийн сангийн зардал**	**0**	**8,383,655,363**
4.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	0	104,519,192
4.2	Үнэт цаасны	0	1,782,813,376
4.3	Зээлийн	0	6,496,322,795
5	**Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]**	**287,789,093,639**	**164,275,148,452**
6	**Бусад орлого**	78,978,351,385	47,042,143,069
6.1	*Хүүгийн бус орлого*	70,268,752,301	46,279,904,084
6.1.1	Арилжааны орлого	8,253,231,483	7,677,710,062
6.1.2	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	5,726,019,671	7,757,414,791
6.1.3	Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	55,980,754,671	30,701,693,434
6.1.4	Бусад хүүгийн бус орлого	308,746,476	143,085,799
6.2	*Бусад орлого, олз*	8,709,599,084	762,238,984
7	**Бусад зардал**	**242,821,531,368**	**127,513,323,622**
7.1	*Хүүгийн бус зардал*	242,239,977,157	126,823,134,617
7.1.1	Бусад эрсдэлийн сангийн зардал	457,697,182	0
7.1.2	Арилжааны зардал	0	0
7.1.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	0	0
7.1.4	Хураамж, шимтгэлийн зардал	19,017,392,557	9,824,999,020
7.1.5	Үйл ажиллагааны бусад зардал	222,764,887,418	116,998,135,597
7.2	*Бусад зардал, гарз*	581,554,211	690,189,005
8	**Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)**	**123,945,913,657**	**83,803,967,899**
9	Орлогын татварын зардал	27,536,094,424	19,638,391,010
10	**Татварын дараах ашиг, алдагдал (8-9)**	**96,409,819,232**	**64,165,576,889**
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	0	0
12	**Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)**	**96,409,819,232**	**64,165,576,889**
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-48,852,862	10,392,942,492
13.1	Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өсөлт, бууралт	0	10,523,933,956
13.2	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний өсөлт, бууралт	-42,932,862	-130,991,464
13.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сангийн өсөлт, бууралт	0	0
13.4	Эрсдэлийн сангийн нөөцийн өсөлт, бууралт	0	0
13.5	Бусад	-5,920,000	0
14	**Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (10+11)**	**96,360,966,370**	**74,558,519,381**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ӨГАНТӨР

БИЗНЕС ХАРИУЦСАН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТЭРГҮҮН ОРЛОГЧ Д.СҮГАР

САНХҮҮГИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ ДЭЖАДАМБАА

ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.БУЯНТОГТОХ

ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХЭЛТСИЙН ХЯНАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН Д.НАРАНЦАЦРАЛ

ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХЭЛТСИЙН ТАЙЛАНГИЙН МЭРГЭЖИЛТЭН Д.ЖАРГАЛМАА

ТӨРИЙН БАНКНЫ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

2026.06.30

	өөрийн хөрөнгийн зүйл	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	**2024 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл**	**188,774,062,500**	**14,652,725,000**	**0**	**42,310,184,890**	**28,308,577,811**	**360,020,674,980**	**634,066,225,181**
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0	0	0	0	**0**
3	**Залруулсан үлдэгдэл**	**188,774,062,500**	**14,652,725,000**	**0**	**42,310,184,890**	**28,308,577,811**	**360,020,674,980**	**634,066,225,181**
4	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	0	0	0	0	0	96,409,819,232	**96,409,819,232**
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	-48,852,862	0	**-48,852,862**
6	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0	0	0	**0**
7	Хуваарилсан ногдол ашиг	0	0	0	0	0	-48,099,631,125	**-48,099,631,125**
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0	0	0	**0**
9	**2025 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл**	**188,774,062,500**	**14,652,725,000**	**0**	**42,310,184,890**	**28,259,724,949**	**408,330,863,087**	**682,327,560,426**
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0	0	0	0	**0**
11	**Залруулсан үлдэгдэл**	**188,774,062,500**	**14,652,725,000**	**0**	**42,310,184,890**	**28,259,724,949**	**408,330,863,087**	**682,327,560,426**
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	0	0	0	0	0	64,165,576,889	**64,165,576,889**
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	-130,991,464	0	**-130,991,464**
14	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	10,537,458,956	0	0	**10,537,458,956**
15	Хуваарилсан ногдол ашиг	0	0	0	0	0	-39,113,985,750	**-39,113,985,750**
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	-13,525,000	0	13,525,000	**0**
17	**2026 оны 6-р сарын 30-ны өдрийн үлдэгдэл**	**188,774,062,500**	**14,652,725,000**	**0**	**52,834,118,846**	**28,128,733,485**	**433,395,979,226**	**717,785,619,057**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ө.ГАНТӨР

БИЗНЕС ХАРИУЦСАН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТЭРГҮҮН ОРЛОГЧ Д.СУГАР

САНХҮҮГИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ Д.ЖАДАМБАА

ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.БУЯНТОГТОХ

ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХЭЛТСИЙН ХЯНАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН Д.НАРАНЦАЦРАЛ

ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХЭЛТСИЙН ТАЙЛАНГИЙН МЭРГЭЖИЛТЭН Д.ЖАРГАЛМАА

Хавсралт №3

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
/2026.01.01-2026.06.30/

2026.07.02

Тайлант хугацаанд "Төрийн банк ХК-ийн сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6.1 дэх заалтад "Банкны "Үйлчилгээний хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл"-д заасан нийтлэг нөхцөлөөр банкны холбогдох бодлого, журамд заасан шаардлагыг хангуулан, олон нийтэд санал болгож буй ердийн журмаар бизнесийн болон төслийн зээлээс бусад жижиг зээл, харилцах, хадгаламж болон карт, цахим банкны үйлчилгээтэй холбогдох хэлцэл байгуулах" гэж заасны дагуу Гүйцэтгэх захирлын эрх хэмжээний хүрээнд нийт 3500 удаагийн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн. Үүнд:

1. Карт – 125
2. Зээл – 37
3. Хадгаламж барьцаалсан онлайн зээл – 795
4. Харилцах болон хадгаламжийн данс – 69
5. Автомат хуримтлал – 2
6. Интернэт банк – 5
7. Мессеж мэдээ, мобайл банк – 7
8. Хувийн дугаар – 5
9. Гадаад валютын арилжааны хэлцэл - 2455

Дээрх сонирхлын зөрчилтэй хэлцлүүд нь "Төрийн банк ХК-ийн сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6.1-д "Банкны олон нийтэд санал болгож буй ердийн журмаар "Үйлчилгээний хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл"-д заасан нөхцөлөөр банкны холбогдох бодлого, журмын дагуу дараах хэлцэл байгуулах" гэж, журмын 4.6.2-д "Банкны тухайн үеийн зарласан ханшаар гадаад валют арилжааны хэлцэл байгуулах" гэж тус тус заасан зохицуулалтын дагуу хийгдсэн байна.

ХЯНАСАН:
КОМПЛАЙНСЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ Б.СУГАР

КОМПЛАЙНСЫН ГАЗРЫН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ЗОРИГТ

БОЛОВСРУУЛСАН:
КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫН
МЭРГЭЖИЛТЭН Ч.ТҮВШИНБАЯР

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Монгол Улсын банк, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 348 дугаар тогтоол, Сангийн сайдын 2009 оны 259 дугаар тушаалын дагуу 100 хувь Төрийн өмчит "Төрийн банк"-ийг үүсгэн байгуулахаар шийдвэрлэж, Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 375 дугаар тушаалаар батлагдсан "Банк түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам"-ыг тус тус үндэслэн 2009 оны арваннэгдүгээр сарын 23-ны өдөр байгуулагдсан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн чуулганаар Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд "Төрийн банк" ХК нь системийн нөлөө бүхий банкнуудаа түүчээлж нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжихээр Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, "Монголын хөрөнгийн бирж" ХК-д үнэт цаасаа бүртгүүлэн, нийт гаргасан хувьцааныхаа 5.71 хувийг олон нийтэд гаргаснаар 25.4 тэрбум төгрөгийг 7,421 хувьцаа эзэмшигчдээс амжилттай татан төвлөрүүлж, нээлттэй хувьцаат компани болсон.

"Төрийн банк" ХК нь 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Гүйцэтгэх захирал, Бизнес хариуцсан Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч, Эрсдэл, санхүү хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч, 5 Дэд захирал, 16 газар, 23 хэлтэс, 10 алба, Улаанбаатар хотод 81 нэгж, Орон нутагт 408 нэгж, БНСУ-д байрлах төлөөлөгчийн газартай буюу нийт 490 нэгж, 350 АТМ болон 8,698 картаар үйлчлэгч байгууллагаар дамжуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Цаашид "Төрийн банк" ХК нь стратеги, бизнес төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөлтийн хэрэгжилтийг хангаж, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах, эрсдэлийн удирдлага ба дотоод хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх, ил тод байдлыг хангах, тогтвортой хөгжил болон ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өсөлт, нөлөөллийн тайлагналыг сайжруулах, компанийн засаглалын чанарыг бэхжүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хувьцаа эзэмшигчид:

"Төрийн банк" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хувьцаа эзэмшлийн бүтцийн хувьд 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Сангийн яам 49.26 хувь, Хадгаламж даатгалын корпораци 45.03 хувь, олон нийт 5.71 хувийг тус тус эзэмшиж байна.



Банкны тухай хууль, Компанийн тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу 2025 оны "Төрийн банк" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулж, "Төрийн банк" ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, "Төрийн банк" ХК-ийн 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилсан тухай тайлан, "Төрийн банк" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд 2025 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай танилцуулж, "Төрийн банк" ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төслийг хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулав.

"Төрийн банк" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Банкны тухай хууль, Компанийн тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу зохион байгуулж, хурлын тэмдэглэл, шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын саналын эрхийн тооллогын баримт бичгийн баталгаажуулсан хувийг 2026 оны 5 дугаар сарын 5-ны өдөр Монголбанканд хүргүүлэв.

Төлөөлөн удирдах зөвлөл:

"Төрийн банк" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын 05 дугаар тогтоолоор "Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам"-ыг олон улсад хэрэгжиж буй засаглалын сайн практик, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчийн болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-д тус тус нийцүүлэн шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Шинэчлэгдэн батлагдсан Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл */цаашид "ТУЗ" гэх/*-ийн ээлжит хурлыг батлагдсан хуваарийн дагуу, шаардлагатай нөхцөлд ээлжит бусаар тухай бүр зохион байгуулж ажилласан.

Тайлант хугацаанд ТУЗ нь банкны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, дунд хугацааны стратеги, зохистой засаглал, эрсдэлийн удирдлагын бодлого, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлт, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, ТУЗ-ийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ажилласан байна.

ТУЗ нь 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт 15 удаа хуралдаж, 31 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Тухайлбал, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийн 2025 оны 4 дүгээр улирал, 2026 оны 1 дүгээр улирлын тайлан, Ногдол ашгийн хэмжээ тогтоох тухай, Олон улсын зах зээлд бонд нэмж гаргах тухай, Банкны 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, Хөндлөнгийн аудитын тайлан, Банкны 2026 оны тогтворжуулах төлөвлөгөө, "Мөнгө угаах терроризмын санхүүжүүлэх эрсдэлийн үнэлэх аргачлал" болон "Төрийн банкны захирлуудын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-д өөрчлөлт оруулах тухай, "Төрийн банкны үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, түрээсийн үйл ажиллагааны журам" батлах тухай зэрэг асуудлыг хэлэлцэн

шийдвэрлэж, 2 үүрэг даалгавар, 55 тогтоол тус тус гаргаж, ТУЗ-ийн бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлсэн.

ТУЗ-ийн хурлын ирц тогтмол 66.6 хувиас дээш хувьтай байсан бөгөөд ТУЗ-ийн гишүүд үүрэг, хариуцлагын хэрэгжилтийн хүрээнд хуралдааны оролцоог тогтмол ханган ажилласан.

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэгт заасны дагуу төрийн өмчийн оролцооны хувь хэмжээг зохистой хэмжээнд хангах, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 10.2 дахь хэсэгт ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 5 нь ердийн, 4 нь хараат бус гишүүн байхаар тогтоож өгсөн.

"Төрийн банк" ХК-ийн ТУЗ-д 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хараат бус гишүүн С.Цэнд-Аюуш, М.Батжаргал, Б.Цэвэгжав, З.Оюунцацрал нар, ердийн гишүүн Б.Ганбат, Х.Пүрэвсүрэн нар ажиллаж, Х.Пүрэвсүрэн ТУЗ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэн ажиллаж байна. ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Тэлмүүн, Г.Золбоо, Л.Сонор нар өөр ажил, албан тушаалд шилжсэн тул ТУЗ-ийн ердийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн болно.

Сангийн сайдаас 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 01/1872, 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 01/3921, 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 01/5693 тоот албан бичгээр тус тус ирүүлсэн удирдамжийн дагуу "Төрийн банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн сонгох бэлтгэл ажлыг зохион байгуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн холбогдох материалыг Монголбанканд мэдэгдэл авахаар хүргүүлсэн болно.

ТУЗ-ийн гишүүдэд 2026 оны эхний хагас жилийн байдлаар "Төрийн банк" ХК-ийн үйл ажиллагааны тайлан, комплайнсын үйл ажиллагаа, мэдээллийн технологийн аудитын тайлан, МУТСТ дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийн тайлан, банкны эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тайлан, Дотоод аудитын газрын тайлан, ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодоос өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг тус тус танилцуулж, цаг үеийн шаардлагатай болон холбогдох мэдээллээр хангасан. Мөн ТУЗ-ийн гишүүдийг чиглүүлэх, мэргэшүүлэх ажлын хүрээнд ТУЗ-ийн хараат бус гишүүд ЕҮ байгууллагаас "Уур амьсгалын эрсдэлийн удирдлага"-ын чиглэлээр үзүүлсэн зөвлөх үйлчилгээний хүрээнд зохион байгуулсан 2 удаагийн сургалт болон СТОУС S1, S2 тайлагналын цахим сургалтад хамрагдсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл:

ТУЗ-ийн даргын үүрэг гүйцэтгэгч:

- Х.Пүрэвсүрэн - МУИС-ийн нягтлан бодогч, эдийн засагч магистр, Голланд Улсын Маастрихтийн менежментийн их сургуульд нягтлан бодох, эдийн засгийн менежментийн чиглэлээр тус тус боловсрол эзэмшсэн. 1992-1996 онд СЭЗИС-д багш, тэнхимийн эрхлэгч, 1996-1997 онд "Говь" ХК-д эдийн

засгийн хэлтсийн дарга, 1997-1999 онд Төрийн өмчийн хороонд албаны дарга, 1999-2016 онд Сангийн яаманд газрын дарга, Сангийн сайдын зөвлөхөөр ажиллаж байсан ажлын туршлагатай.

ТУЗ-ийн гишүүд:

- Б.Ганбат - ЗХУ-ын Дотоод явдлын яамны Академийн хууль эрх зүй бакалавр, ИБУИНВУ-ын Коммонвелт хуулийн коллежид Хууль эрх зүйн магистрын зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 1995 оноос хойш Сангийн яаманд хуулийн зөвлөх, мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга, Сайдын зөвлөлийн нарийн бичгийн дарга, газрын орлогч дарга, газрын дарга, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт газрын дарга, Тэргүүн дэд даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат хуульч.

- Хараат бус гишүүн М.Батжаргал - Хөдөө аж ахуйн дээд сургуулийг эдийн засагч бакалавр, эдийн засгийн ухааны магистрын зэргээр боловсрол эзэмшсэн. 1975-1989 онд Улсын банканд эдийн засагч, орлогч дарга, Увс аймгийн Арбитр - Ерөнхий арбитрч, 1993-2008 онд Монголбанканд газрын захирал, ерөнхий захирал, ахлах ажилтан, ахлах хянан шалгагч, Хяналт шалгалтын хэлтсийн захирал, Дотоод аудитын газрын ахлах хянан шалгагч, аудитын зөвлөхөөр тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат эдийн засагч.

- Хараат бус гишүүн С.Цэнд-Аюуш - Санхүүч, ОХУ-ын Эрхүү хотын Улс Ардын Аж Ахуйн дээд сургуульд санхүүч бакалаврын зэргээр боловсрол эзэмшсэн. 1978-2015 онд Сангийн яаманд Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар мэргэжилтэн, ахлах мэргэжилтнээр тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат эдийн засагч.

- Хараат бус гишүүн З.Оюунцацрал - Эдийн засгийн коллежийн банк, зээлийн эдийн засагч бакалавр, БНСУ-ын Хандонг глобал их сургуулийн бизнесийн удирдлагын магистр, зэргээр боловсрол эзэмшсэн. СЭЗИС-ийн удирдахуйн ухааны доктор зэрэгтэй. 1996 оноос өнөөг хүртэл СЭЗИС-д багш, тэнхимийн эрхлэгч, профессороор ажилласан туршлагатай.

- Хараат бус гишүүн Б.Цэвэгжав - СЭЗИС-ийн банкны удирдлагын бакалавр, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн бизнесийн удирдлагын магистр зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 2002-2014 онд Капитрон банканд нягтлан бодогч, эдийн засагч, дилер, салбарын захирал, 2014-2015 онд Богд банк байгуулах төсөл, хөрөнгийн удирдлага хариуцсан гишүүн, 2015-2017 онд "Мегамакс групп" ХХК-д санхүү хариуцсан захирал, 2017-2023 онд "Эрдэнэс Монгол" ХХК-д албаны дарга, хэлтсийн дарга, 2022-2023 онд "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн дарга, "Эрдэнэс силвер ресурс" ХХК, "Гашуун сухайт авто зам" ХХК, "Метан газ ресурс" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан ажлын туршлагатай.

Гүйцэтгэх захирал:

- Ө.Гантөр - Төрийн банкны Гүйцэтгэх захирал. СЭЗДС-ийг Банк санхүүч, бакалавр, KDI School of PPM Korea сургуулийг Удирдлагын ухааны магистрын зэргээр боловсрол эзэмшсэн. 1996-1997 онд "Монком" ХХК-д Нягтлан бодогч, 1997-1999 онд "ММ Инвест" банканд эдийн засагч, 1999-2011 онд Монголбанканд Хянан шалгагч, Ахлах хянан шалгагч, 2011-2013 онд Төрийн банканд Дэд захирал, 2013-2018 онд Монголбанканд Ахлах хянан шалгагч, 2018-2019 онд Төрийн банканд Байгууллагын банкны газрын захирал, 2019-2020 онд Төрийн банканд Тэргүүн дэд захирлаар тус тус ажилласан ажлын туршлагатай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод:

Тус банкны ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд ТУЗ-ийн 2025 оны 5 дугаар сарын 29-ны өдрийн 56 дугаар тогтоолын дагуу өөрчлөлт оруулсан.

Аудитын хороо

Хорооны дарга:	С.Цэнд-Аюуш	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүд:	З.Оюунцацрал	ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Х.Пүрэвсүрэн	ТУЗ-ийн гишүүн

Эрсдэлийн удирдлагын хороо

Хорооны дарга:	З.Оюунцацрал	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүд:	Б.Цэвэгжав	ТУЗ-ийн хараат бус гишүүн
	М.Батжаргал	ТУЗ-ийн гишүүн

Нэр дэвшүүлэх хороо

Хорооны дарга:	М.Батжаргал	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүд:	Г.Золбоо	ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Б.Ганбат	ТУЗ-ийн гишүүн

Цалин урамшууллын хороо

Хорооны дарга:	М.Батжаргал	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүд:	С.Цэнд-Аюуш	ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Х.Пүрэвсүрэн	ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороог ТУЗ-ийн хараат бус гишүүд даргалан ажиллаж байна.

Аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо банкны нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, ТУЗ-өөс баталсан банкны стратеги төлөвлөгөө, банкны бодлогын хэрэгжилт, банкны үндсэн үйл ажиллагааны явцад хийгдэх гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох асуудал, түүний үнэн бодит байдалд хяналт тавих, банкны дотоод болон хөндлөнгийн аудитын цар хүрээг

тодорхойлох, үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх, хөндлөнгийн болон дотоод аудит, комплайнсын хяналтын хараат бус байдлыг баталгаажуулах, хараат бус байдалд учирч болзошгүй эрсдэл, түүнийг хэрхэн удирдаж байгаа талаарх хэрэгжилтийн үр дүнг хангаж ажиллах чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Аудитын хорооны ээлжит хурал улирал бүр тогтмол зохион байгуулагдаж, 2026 оны эхний хагас жилийн байдлаар 10 удаа хуралдан, 28 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 24 үүрэг даалгавар өгч, ТУЗ шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангаж, оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэн, хорооны эрх үүргийг хэрэгжүүлэн ажилласан.

Эрсдэлийн удирдлагын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо банкны үйл ажиллагааны чиглэл бүрд үүсэж болох эрсдэлийн түвшнийг тодорхойлох, илрүүлэх, эрсдэлийг бууруулах, арилгахад шаардлагатай арга хэмжээг авах зэргээр эрсдэлийн оновчтой, шуурхай, хараат бус удирдлагыг хэрэгжүүлэх, Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хянах тогтолцоог бүрдүүлэх, банкны зохистой, чадварлаг, мэргэшсэн эрсдэлийн удирдлага, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх эрсдэлийг үнэлэх, банкны үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлийг удирдах чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлыг улирал бүр тогтмол зохион байгуулж, 2026 оны эхний хагас жилийн байдлаар 6 удаагийн хурлаар 15 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 10 үүрэг даалгавар өгч, Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангаж, оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэн, хорооны эрх үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Нэр дэвшүүлэх хороо

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь банкны залгамж халааны бодлогыг тодорхойлох, банкны Хяналтын зөвлөлийн гишүүн, эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах, ажлын гүйцэтгэлд үнэлэлт өгөх, банкны эрх бүхий албан тушаалтны мэдлэг, чадвар, ажлын туршлагын талаар дүгнэлт гаргах, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн бие даасан, хараат бус байдлыг тогтоох, тэдгээрийг сургах, мэргэшүүлэх болон хувьцаа эзэмшигчдээс ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох, чөлөөлөх зэрэг асуудлаар мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Нэр дэвшүүлэх хороо 2026 оны эхний хагас жилийн байдлаар 4 удаа хуралдаж, ТУЗ-ийн шийдвэр гаргалтад шаардлагатай санал дүгнэлт, мэдээллээр ханган ажилласан.

Цалин урамшууллын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо нь Банкны алсын хараа, онцлогт тохирсон, шударга ил тод, зах зээлд өрсөлдөхүйц нөхцөлийг хангасан, ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур, банкны ашиг болон ажлын гүйцэтгэлд суурилсан ажилтны нийгмийн баталгааг хангаж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн цалин урамшууллын бодлогыг тодорхойлоход мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагааг явуулдаг.

Банкны цалин урамшууллын бодлого тогтворжсон, шинэчлэх шаардлагагүй байсантай холбоотойгоор тус хороо 2026 оны эхний хагас жилийн байдлаар 1 удаа хуралдаж 1 асуудал хэлэлцэн шийдвэрлэж хорооны эрх, үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглалын алба

ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын алба нь Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, "Төрийн банк" ХК-ийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс", Монголбанкнаас баталсан "Банкны зохистой засаглалын журам"-ын хэрэгжилтийг хангуулах, банкны зохистой засаглалын бодлогыг хэрэгжүүлэх, ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны зохион байгуулалт, банкны үйл ажиллагааны тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг хангуулах, ТУЗ-ийн гишүүдийн идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын алба тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, түүний дэргэдэх хороодын хурлыг зохион байгуулж, хурлаар хэлэлцэх асуудлын хууль зүйн үндэслэл, холбогдох бусад эрх зүйн хэмжээний нийцэл зэргийг хянан ажилласан байна.

Тайлант хугацаанд "Төрийн банк" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, түүний дэргэдэх хороодын нийт 37 удаагийн хурлыг зохион байгуулж, 82 асуудал хэлэлцэхэд оролцон ажиллаж, 57 тогтоолын хууль зүйн үндэслэлийг няггтлан, хурлуудын тэмдэглэлийг холбогдох журамд тусгасан хугацаанд багтаан хөтөлж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга, ТУЗ-ийн дарга, гишүүдээр хянуулан баталгаажуулж, тогтоолын биелэлтийг Гүйцэтгэх удирдлага болон Дотоод аудитын газраас гаргуулан нэгтгэж, ТУЗ-д танилцуулж ажилласан болно.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн бүтэц, хараат бус байдал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдал, аудит, хяналт, эрсдэлийн удирдлага, цалин урамшууллын бодлого, оролцогч талуудын эрх ашиг, компанийн соёл, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангах чиглэлээр холбогдох бодлого, журам, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн. Мөн Монголбанканд банкны зохистой засаглалын үнэлгээний тайланг, Санхүүгийн зохицуулах хороонд Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайланг тус тус тогтоосон хугацаанд хүргүүлж ажилласан.

"Төрийн банк" ХК нь Монголбанкны 2025 оны банкны зохистой засаглалын үнэлгээгээр "Сайн засаглалтай буюу банкны удирдлагын үйл ажиллагаа хэвийн банк" гэж үнэлэгдэж, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны зохистой засаглалын үнэлгээгээр 95.8 хувьтай үнэлэгдсэн байна.

Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн санал, зөвлөмжид үндэслэн цаашид ТУЗ болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, тайлагналын чанар, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, тогтвортой хөгжил, ногоон санхүүжилт болон оролцогч талуудын эрх ашгийн тайлагналыг илүү хэмжигдэхүйц болгох чиглэлээр ажиллана.

Мэдээллийг гаргасан:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Э.Уянга/